

# **“РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” УТУГ-Н ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН АЖИЛТНЫ АЖЛЫН ХУВЦАСНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

## **1. Ажлын тусгай хувцас**

Ажлын тусгай хувцасны дизайн, үйлдвэрлэл дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

1.1.Ажлын тусгай хувцас нь “Ажлын тусгай хувцас – ерөнхий шаардлага MNS13688:2000” Монгол улсын стандарттай дүйцэхүйц шаардлагыг хангасан байна.

1.2.Хувцасны материал нь эрх бүхий байгууллагаар шалгагдаж баталгаажсан, бат бөх хийгдсэн, эдийн засгийн үр ашигтай, бүрдэл хэсгүүд нь хүний хөдөлгөөнд саад болохгүй байна.

1.3.Хөдөлгөөн болон гадаад орчны хүчин зүйл, сөрөг нөлөөллийг тооцсон хэрэглээний хугацааг урьдаас тооцож баталгаажуулсан байх

1.4.Ажлын тусгай хувцсыг үйлдвэрлэснээс хойш 2-оос доошгүй жил ердийн нөхцөлд хадгалсны дараа тэдгээрийг ашиглах боломжтой байх

1.5.Хувцасны масс нь түүнийг өмсөж байгаа хүний ая тухыг хангах ба биеийн хүчний ачааллыг багасгахын тулд бололцооны хирээр бага байна.

1.6.Хэрэглээний дараа цэвэрлэхэд хялбар байх. Энгийн болон химийн аргаар цэвэрлэх боломжтой байх

1.7.Цахилгаанжихгүй, болзошгүй цахилгаан нумын түлэгдэлт, галын үед хувцасны бүрдэл хэсэг хүний биед наалдахгүй. Хүний биетэй шүргэлцэх хэсэг цэвэр даавуугаар хийгдсэн байна.

1.8.Ажлын үед шаардлагатай багаж хийх халаас, өндрөөс унахаас хамгаалах бүс зүүх бололцоотой байх. Дээшээ авирах болон биеийн суусан болон бөхийх үед хөдөлгөөнд саад болохооргүй байна.

1.9.Өндрөөс унахаас хамгаалах бүс зүүх үед хувцасны хүний биед хүрэлцэх хэсгүүд нь аливаа цочроо, шархлаа, бие барилт үүсгэхгүй байх, бүрдэл хэсгүүд саад болохгүй байх

1.10.Өвдөг тохой, өгзөгийн хэсгээр нэмэлт давхарлагаатай байна

1.11.Харанхуй, гэрэлтүүлэг муутай үед хүний нүдэнд өртөх зорилгоор цээж болон нурууны ар хэсгээр гэрэлтдэг оруулгатай байна. Оруулгын өнгө саарал байна.

1.12.Хүрэм нь хар хөх өнгөтэй, зах нь хувцасны үндсэн өнгөөр, эргэсэн сорочкан хэвтээ, ханцуй нь манжеттай ба ихэсгэж багасгах боломжтой байх.

1.13.Хүрэмний энгэрийн дээд хэсэг хөндлөн оруулагатай ба улаан өнгөтэй байна.

1.14.Далд цахилгаан товчлоостой ба цахилгаанаар тоос, шороо орохоос сэргийлсэн нэмэлт дээрээс нь дарсан дарлагатай, дарлага нь товчилдог.

1.15.Энгэртээ 2 ил халаастай ба товчилдог даравчтай, нэг халаасанд нь үзэг хийх оруулагатай, ташаандаа 2 талдаа ил эзлэхүүнтэй халаастай, халаас нь товчилдог даравчтай байна.

1.16.Зүүн халаасны дээр компанийн логотой, ар хэсэг болон зүүн халаасны дээр **“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ** гэсэн улаан өнгийн бичиглэлтэй байна.

1.17.Хүрэм нь доод талаараа манжеттай байх ба томсгож багасгах зориулалтын сойлттой байх.

1.18.Өмд 2 ташаандаа далд ташуу халаастай, 2 хажуу талдаа тагтай эзэлхүүнт халаастай, дарлага нь товчтой байх.

## **2. Өвлийн ажлын хувцасны загвар**

Өвлийн ажлын хувцасны загвар, хийцэд дараах зохион бүтээлт, хийцүүдийг тусгасан байна.

Үүнд:

2.1.MNS 6306:2012 “Тусгай зориулалтын дулаан хувцас.Ерөнхий шаардлага.” стандартыг хангахуйц байна.

2.2.Хувцасны материал хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүний биед нөлөөлөх химийн болон хорт бодисын хүчин зүйлгүй байна.

2.3.Өвлийн хувцас нь -30 °C-ээс -40°C хүртэлх температурт өмсөхөөр зориулагдсан дулаалгатай, салдаг хонины нэхий түүнтэй дүйцэхүйц доторлогоотой, үстэй захтай, юдэнтэй /салдаг/ байна.

2.4.Хүрэм нь бүсэлхийн хэсэгт салхи орохоос хамгаалж дотор талдаа татуургатай, хөлс гадагшлуулах материалаар хийгдсэн байна. Хуванцар цахилгаан товчтой ба дулаан алдах, тоос шороо орохоос сэргийлсэн нэмэлт товчилдог дарлагатай, салдаг малгайтай байх. Энгэрийн дээд хэсэгтээ тууш эзэлхүүнтэй далд халаастай. Ташаандаа 2 талдаа ил эзлэхүүнтэй халаастай байна. Халаас нь товчилдог даравчтай байх, энгэр ба арын хэсэг, ханцуйнд гэрэл ойлгогч оруулагатай байна.

2.5.Хүрэмний 2 энгэрт ил халаастай, халаас нь даравчтай, 2 хажуу талд тагтай эзэлхүүнт халаастай, дарлага нь товчилдог байх.

2.6.Өмд нуруугаар салхи орохоос хамгаалах өндөр нуруувчтай, бүсэлхийгээр сунаж агших чөлөөтэй өмсөх резинен оруулагатай, дарлага кноптой, хөвөнтэй хэрээсэн дотортой байна. Өвдөг болон өгзөгний хэсэгт нэмэлт давхарлагатай байна.Ташааны оёдолд орсон ташуу халаастай, шуумагт гэрэл ойлгогч оруулгатай байх.

2.7.Зүүн халаасны дээр компанийн логотой, ар хэсэг болон зүүн халаасны дээр **“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ** гэсэн улаан өнгийн бичиглэлтэй байна.

2.8.Хэрэглээний дараа хялбар цэвэрлэгддэг байх. Энгийн болон химийн аргаар цэвэрлэх боломжтой байх. Цэвэрлэгээний үед болон нойтон

боловсруулалтын үед будаг гарахгүй, өнгөө алдаж агшихгүй байх. Олон удаагийн угаалтанд тэсвэртэй оёдолтой ба давхар оёдолтой байх. Хувцасны өнгө хар хөх байна.